**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СЭА-2025/172/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.selenge@audit.gov.mn<br>Сүхбаатар сум<br>2025 он | Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа<br>Утас: 70363040<br>Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Батмөнх<br>Утас: 70363036<br>Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn<br><br>Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа<br>Утас: 99088151<br>Цахим хаяг: arifin.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ....................................................................................................4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ......................................................6

3. Санхүүгийн тайлангийн тодруулга....................................................................................11

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..........................................................................11

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин..........................................................................11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.................................................................12

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ...................12

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..................................................................13

4. Аудитын тайлан ..................................................................................................................15

4.1 Ерөнхий зүйл ..................................................................................................................15

4.2 Материаллаг байдал ......................................................................................................15

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.........................................................................15

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .................15

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................16

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................................17

5. Аудитын илрүүлэлт .............................................................................................................17

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.................................................................19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУЯ | Боловсрол шинжлэх ухааны яам |
| БЕГ | Боловсролын ерөнхий газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТБОНӨХБАҮХА | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **116,046,800.92** | **82,197,810.06** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 60,863,903.21 | 30,973,358.95 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 60,863,903.21 | 30,973,358.95 |
| **3121** | **Төгрөг** | 60,863,903.21 | 30,973,358.95 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 60,863,903.21 | 30,973,358.95 |
| **33** | **АВЛАГА** | **5,127,332.68** | |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 5,127,332.68 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 50,055,565.03 | 51,224,451.11 |
| **351** | **Түүхий эд материал** | 4,400,750.00 | 4,155,750.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 4,376,000.00 | 4,131,000.00 |
| 35130 | Эм боох материал | 24,750.00 | 24,750.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 45,654,815.03 | 47,068,701.11 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,875,976.05 | 30,620,716.05 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 19,833,739.78 | 16,447,985.06 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **429,011,320.74** | **399,728,079.11** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 429,011,320.74 | 399,728,079.11 |
| **392** | **Биет хөрөнгө** | 367,453,987.42 | 336,048,079.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 329,964,934.99 | 329,964,934.99 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (44,688,040.59) | (54,008,628.39) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 73,362,877.40 | 79,500,727.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (41,295,653.93) | (56,725,528.28) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,135,865.88 | 20,995,865.88 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (11,273,297.13) | (14,639,869.17) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,092,456.80 | 2,092,456.80 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (615,428.40) | (738,514.08) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 68,797,896.45 | 68,797,896.45 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (30,198,590.71) | (40,362,229.15) |
| 39217 | Ном | 1,170,966.66 | 1,170,966.66 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 61,557,333.32 | 63,680,000.00 |
| 39301 | Програм хангамж | 0.00 | 800,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | (800,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 64,480.000.00 | 63,680,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (2,922,666.68) | 0.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **545,058,121.66** | **481,925,889.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **345,791.37** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 90.00 | 345,791.37 |
| **413** | **Өглөг** | 0.00 | 345,791.37 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 345,791.37 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **545,058,121.66** | **481,580,097.80** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **545,058,121.66** | 481,580,097.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 486,916,191.33 | 486,916,191.33 |
| 51101 | Өмч: - төрийн | 486,916,191.33 | 486,916,191.33 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 19,757,075.08 | (43,720,948.78) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (7,159,345.07) | 21,879,741.76 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 26,916,420.15 | (65,600,690.54) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 38,384,855.25 | 38,384,855.25 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **545,058,121.66** | **481,925,889.17** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **551,973,860.20** | **625,152,576.79** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,523,000.00** | **14,280,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,523,000.00 | 14,280,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **545,450,860.20** | **610,872,576.79** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 496,526,800.00 | 532,187,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 496,526,800.00 | 532,187,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 48,924,060.20 | 78,685,076.79 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 48,924,060.20 | 78,685,076.79 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **525,057,440.05** | **690,753,267.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **525,057,440.05** | **690,753,267.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 525,057,440.05 | 690,753,267.33 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **351,625,559.49** | **465,786,123.05** |
| 210101 | Үндсэн цалин | 253,980,448.49 | 313,284,466.85 |
| 210102 | Нэмэгдэл | 84,700,939.00 | 133,852,476.14 |
| 210104 | Урамшуулал | 12,944,172.00 | 18,649,180.06 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,792,290.44** | **52,175,750.28** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,887,575.43 | 37,274,505.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,526,738.84 | 4,464,920.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,721,354.47 | 2,151,621.76 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 603,661.60 | 1,623,880.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,052,960.10 | 6,660,821.60 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,924,060.20** | **59,685,076.79** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,020,770.20 | 9,225,436.79 |
| 210302 | Түлш, халаалт | 29,500,000.00 | 45,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,403,290.00 | 5,459,640.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **0.00** | **245,000.00** |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 245,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **34,743,450.00** | **35,867,594.20** |
| 210502 | Хоол, хүнс | 34,743,450.00 | 35,856,594.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 11,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,470,000.00** | **18,809,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 6,470,000.00 | 18,809,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **617,826.00** | **1,180,300.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 617,826.00 | 1,180,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 48,884,253.92 | 57,004,423.01 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,592,363.00 | 14,570,664.72 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 367,300.00 | 4,029,999.98 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 41,924,590.92 | 38,403,758.31 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **26,916,420.15** | **(65,600,690.54)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **251,080,700.00** | **610,872,576.79** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **244,557,700.00** | **610,872,576.79** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 212,761,900.00 | 532,187,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 212,761,900.00 | 532,187,500.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 31,795,800.00 | 78,685,076.79 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 31,795,800.00 | 78,685,076.79 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 240,395,656.63 | 640,763,121.05 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 240,395,656.63 | 640,763,121.05 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 240,395,656.63 | 640,763,121.05 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 159,773,896.33 | 455,534,154.36 |
| 210101 | Үндсэн цалин | 120,343,161.36 | 303,955,889.66 |
| 210102 | Нэмэгдэл | 34,370,649.00 | 132,929,084.64 |
| 210104 | Урамшуулал | 5,060,085.97 | 18,649,180.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,424,100.00 | 56,954,594.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,647,900.00 | 40,411,756.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,194,100.00 | 5,119,129.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,755,200.00 | 2,186,018.25 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 438,800.00 | 1,814,473.08 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,388,100.00 | 7,423,217.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 22,921,084.30 | 59,685,076.79 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,824,014.30 | 9,225,436.79 |
| 210302 | Түлш, халаалт | 16,500,000.00 | 45,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,597,070.00 | 5,459,640.00 |
| 2105 | Нормативт зардал | 18,768,250.00 | 34,911,495.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,768,250.00 | 34,911,495.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,447,000.00 | 19,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,447,000.00 | 19,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 358,426.00 | 1,180,300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 358,426.00 | 1,180,300.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,702,900.00 | 13,497,499.98 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,565,600.00 | 9,185,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 137,300.00 | 4,312,099.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 10,685,043.37 | (29,890,544.26) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 4,525,043.37 | (29,890,544.26) |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **10,133,577.10** | **60,863,903.21** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **14,445,516.80** | **30,973,358.95** |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **486,916,191.33** | 38,384,855.25 | **(7,159,345.07)** | **532,949,641.72** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **486,916,191.33** | **38,384,855.25** | **(7,159,345.07)** | **518,141,701.51** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 26,916,420.15 | 26,916,420.15 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **486,916,191.33** | **38,384,855.25** | **19,757,075.08** | **545,058,121.66** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.00 | 2,122,666.68 | 2,122,666.68 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **486,916,191.33** | **38,384,855.25** | **21,879,741.76** | **547,180,788.34** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (65,600,690.54) | (65,600,690.54) |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **486,916,191.33** | **38,384,855.25** | **(43,720,948.78)** | **481,580,097.80** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **671,836,300.00** | **640,763,121.05** | **31,073,178.95** | **95.4** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **671,836,300.00** | **640,763,121.05** | **31,073,178.95** | **95.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **671,836,300.00** | **640,763,121.05** | **31,073,178.95** | **95.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **480,730,000.00** | **455,534,154.36** | **25,195,845.64** | **94.8** |
| 210101 | Үндсэн цалин | 325,992,900.00 | 303,955,889.66 | 22,037,010.34 | 93.2 |
| 210102 | Нэмэгдэл | 141,769,300.00 | 132,929,084.64 | 8,840,215.36 | 93.8 |
| 210104 | Урамшуулал | 12,967,800.00 | 18,649,180.06 | (5,681,380.06) | 143.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **57,963,200.00** | **56,954,594.92** | **1,008,605.08** | **98.3** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,415,500.00 | 40,411,756.46 | (996,256.46) | 102.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,636,500.00 | 5,119,129.62 | (482,629.62) | 110.4 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,318,500.00 | 2,186,018.25 | 132,481.75 | 94.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,318,500.00 | 1,814,473.08 | 504,026.92 | 78.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,274,200.00 | 7,423,217.51 | 1,850,982.49 | 80.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,695,000.00** | **59,685,076.79** | **9,923.21** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,000,000.00 | 9,225,436.79 | (1,225,436.79) | 115.3 |
| 210302 | Түлш, халаалт | 45,000,000.00 | 45,000,000.00 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,695,000.00 | 5,459,640.00 | 1,235,360.00 | 81.5 |
| **2105** | **Нормативт зардал** | **38,430,300.00** | **34,911,495.00** | **3,518,805.00** | **90.8** |
| 210502 | Хоол, хүнс | 38,430,300.00 | 34,911,495.00 | 3,518,805.00 | 90.8 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,000,000.00** | **19,000,000.00** | **-** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 19,000,000.00 | 19,000,000.00 | - | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,180,300.00** | **1,180,300.00** | **-** | **100.0** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,180,300.00 | 1,180,300.00 | - | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,837,500.00** | **13,497,499.98** | **1,340,000.02** | **91.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,765,000.00 | 9,185,400.00 | 1,579,600.00 | 85.3 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,072,500.00 | 4,312,099.98 | (239,599.98) | 105.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **671,836,300.00** | **610,872,576.79** | **60,963,723.21** | **90.9** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **532,187,500.00** | **532,187,500.00** | **-** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 532,187,500.00 | 532,187,500.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **78,695,000.00** | **78,685,076.79** | **9,923.21** | **100.0** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 78,695,000.00 | 78,685,076.79 | 9,923.21 | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **60,953,800.00** | **00.00** | **60,953,800.00** | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 60,953,800.00 | 00.00 | 60,953,800.00 | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **60,863,903.21** | **(60,863,903.21)** | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **30,973,358.95** | **(30,973,358.95)** | **-** |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **24** | **24** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 14 | 14 | - | 100.0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Суралцагчийн эзэмших чадамж танин мэдэхүйн, эрүүл мэнд, нийгэм сэтгэл хөдлөлийг хөгжүүлэхэд бүх талын оролцоо хамтын ажиллагааг хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулах гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл,үр дүнд суурилан санхүүжүүлэх журам” ;*

- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор"Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл,чанар,үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам";*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,254.9, мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 60,863.9 | 30,973.4 | (29,890.5) |
| Авлага | 5,127.3 | 0.0 | (5,127.3) |
| Бараа материал | 50,055.6 | 51,224.4 | 1,168.8 |
| Үндсэн хөрөнгө | 431,134.0 | 399,728.1 | (31,405.9) |
| **Нийт хөрөнгө** | **547,180.8** | **481,925.9** | **(65,254.9)** |
| Өр төлбөр | | 345.8 | 345.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 547,180.8 | 481,580.1 | (65,600.7) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **547,180.8** | **481,925.9** | (65,254.9) |

Дээрх санхүү байдлын тайлангийн үзүүлэлтээс харахад дараах дансанд өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 30,973.4 мянган төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 7.9-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 51,224.4 мянган төгрөг болж 1,168.8 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалт болон Японы хүүхдийн ивээх сангаас үнэ төлбөргүй авсан бараа материалыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 399,728.1 мянган төгрөг болж 31,405.9 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд 38,403.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцон бүртгэсэн нь нөлөөлсөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 605,480.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,695.0 мянган

төгрөг, нийт 684,175.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг 115,232.6 мянган төгрөгөөр бууруулж, 568,942.9 мянган төгрөгөөр батлаас тайлант онд төсөвт 7 удаа зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 532,187.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,695.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 60,953.8 мянган төгрөг, нийт 671,836.3 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 532,187.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,695.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 60,953.8 мянган төгрөг, нийт 671,836.3 мянган төгрөг бүрдүүлэхээс улсын төсвөөс 532,187.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 78,685.4 мянган төгрөг зэрэг нийт 610,872.6 мянган төгрөг төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс 29,890.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 640,763.1 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 26,988.3 мянган төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоол зардлыг 3,518.8 мянган төгрөг тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Улсын төсвөөс санхүүжих** | | | | |
| 1 | 80233-Хүүхэд хамгаалал | 514.7 | 514.0 | 0.7 | 0.0 |
| 2 | 81605-Эрүүл мэндийг дэмжих | 912.7 | 850.0 | 62.7 | 93.1 |
| 3 | 81607-Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 38,430.3 | 34,911.5 | 3,518.8 | 90.8 |
| 4 | 81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр | 2,043.7 | 2,043.7 | 0.0 | 100.00 |
| 5 | 81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх | 911,6 | 521.0 | 390.6 | 57.1 |
| 6 | 81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 540,941.5 | 513,953.2 | 26,988.3 | 95.1 |
| 7 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 9,296.8 | 9,194.5 | 102.1 | 98.9 |
| 8 | 83603-Нэмэлт -Дээд шатны төсвөөс хуваарилсан | 90.0 | 90.0 | 0.0 | 100.0 |
| | **Дүн** | **593,141.3** | **562,077.7** | **31,063.6** | **94.7** |
| | **Орон нутгийн төсвөөс** | | | | |
| 9 | 8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал | 78,695.0 | 78,685.4 | 9.6 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **Дүн** | **78,695.0** | 78,685.4 | **9.6** | **100.0** |
| | **Нийт дүн** | **671,836.3** | **640,763.1** | **31,073.2** | **95.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны *"Чиглэл хүргүүлэх тухай"* албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд хүүхдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг харьцуулалтын аргаар зарласан боловч оролцогч ирээгүй тул Гацал хайрхан ХХК, Цахим ертөнц ХХК, Галил этоос ХХК, Бугат хад ХХК, Асралт өндөр ХХК, иргэн Д.Мөнхцэцэг нартай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Ари файнэнс аудит" ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит “ ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 525,057.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,875.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 1 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй уялдуулан албан хэрэг эрхлэх ажлыг цахимаар гүйцэтгэж байгаатай холбогдон бичиг хэргийн зардлыг хэмнэсэн, хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл /бүтэн жилээр/

Нийцсэн бөгөөд зохистой байх баталмж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр "Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай" албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийг зориулалт бусаар зарцуулсан, авлагатай ажилласан зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

*Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 8,146.8 | 3 | 8,146.8 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **8,146.8** | **4** | **8,146.8** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 16,402.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 16,402.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж баталгаажуулав. Үүнд:

- Дэээрэт Олон улсын байгууллагаас үнэ төлбөргүй ирсэн 8,140.0 мянган төгрөгийн бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн.
- Дэээрэт Олон улсын энэрлийн байгууллагаас үнэ төлбөргүй ирсэн 6,140.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан.
- Биет бус хөрөнгө (газар)-д элэгдэл тооцож зардлаар бүртгэсэн 2,122,7 мянган төгрөгийн алдааг залруулав.

Аудитаар нийт **5,112.6** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 345.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 4,766.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 345.7 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Бараа материалын данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:* Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн **4,766.9** мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*Өгсөн зөвлөмж:* Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5[1] дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй ирсэн бараа материалын ангиллыг буруу бүртгэсэн | 1 | 8,140.0 | | | 1 | 8,140.0 | 1 | 8,140.0 | | | | |

[1] Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй | 1 | 6,140.0 | 1 | 6,140.0 | | | 1 | 6,140.0 | | | | |
| Биет бус хөрөнгө (газар)-д элэгдэл тооцож зардлаар бүртгэсэн. | 1 | 2,122,7 | | | 1 | 2,122,7 | 1 | 2,122,7 | | | | |
| **Дүн** | **3** | **16,402.7** | **1** | **6,140.0** | **2** | **10,262.7** | **3** | **16,402.7** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өр төлбөр үүсгэсэн | 1 | 345.7 | | | 1 | 345.7 | | | | | | |
| Эцэг эхчүүдээс авсан хичээлийн болон ариун цэврийн хэрэглэгдэхүүнийг санхүүгийн тайланд тусгаагүй. | 1 | 4,766.9 | | | | | 1 | 4,766.9 | | | | |
| **Дүн** | **2** | 5,112.6 | | | **1** | **345.7** | **1** | 4,766.9 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |